

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017.06.27

Мандалговь

Тус салбар зөвлөл нь Төрийн албаны шинэтгэлийн стратегүүд болон Засгийн газрын шинэчлэлийн бодлогыг орон нутагт өргөн далайцтай хэрэгжүүлж үр дүнд хүргэхийг зорилго болгон энэ ажлын хүрээнд үндсэн ажлаа төлөвлөж, тодорхой удирдамж, чиглэл, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг улирал тутам дүгнэж, эрчимжүүлж ажиллалаа.

Салбар зөвлөлөөс 2017 оны эхний хагас жилд зохион байгуулж хэрэгжүүлсэн ажил, үр дүнг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн ажил дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу танилцуулж байна.

Нэг. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил үр дүн

Тус Салбар зөвлөлөөс төрийн албаны хууль тогтоомж, стандартуудын хэрэгжилтийг хангаж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, судалгаа мэдээлэл, цахим технологид суурилсан ажил үйлчилгээг нэвтрүүлэх, төрийн албан хаагчдын чадавх, ажлын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэхэд ахиц дэвшил гаргах зорилт дэвшүүлэн тодорхой ажлууд зохион байгуулж ажилласан.

Засгийн газрын 2007 оны 186 дугаар тогтоолоор баталсан төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх улсын төлөвлөгөөнд үндэслэн, аймгийн салбар зөвлөлийн 2017 оны төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан.

Хоёр. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн.

Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 91 дүгээр албан тоотой ирүүлсэн загварын дагуу аймгийн салбар зөвлөлийн 2017 оны төлөвлөгөөг стратегийн 5 үндсэн зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэх 40 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур тоо чанар, хугацаагаар тодорхойлон төлөвлөж, салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулан хэрэгжүүлж, улирал тутам үр дүнг тооцож ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 1-р улирлын байдлаар 82,81 хувь, Эхний хагас жилийн байдлаар 93,03 хувь, жилийн эцсийн байдлаар 96,0 хувьтай байна. */Салбар зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайланд хавсаргае./*

Төрийн албаны салбар зөвлөлийн стратегийг тодорхойлох, Цахим хуудсанд иргэд олон нийт, албан хаагчдын санал хүлээн авах цонх нээж, иргэдийн саналыг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх, Хөндлөнгийн байгууллагаар салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийлгэх зэрэг чиглэлээр хийгдэх ажлуудыг цаашид эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.

Гурав. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал

2017 оны эхний хагас жилд Салбар зөвлөлийн хурлыг 10 удаа хийсэн. Зөвлөлийн хурлаар зарим албан хаагчдад төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв олгох, “Оны шилдэг менежер” шалгаруулах, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын комисс байгуулах, сонгон шалгаруулалтын дүнгийн тухай, дүгнэлт гаргах тухай, албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай, зарим

иргэдийн өргөдөл гомдлын тухай, төрийн албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулж явуулах, шалгалтын дүнгийн тухай, хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, төрийн байгууллагуудад төрийн албаны стандартын хэрэгжилтийг шалган зааварлах тухай зэрэг цаг үеийн тулгамдсан 67 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 30 тогтоол гаргасан.

Салбар зөвлөлийн 2015 оны хурлын шийдвэрийн хэрэгжилтийн тайланг Салбар зөвлөлийн 2016 оны 2 дугаар хуралдаанаар, 2016 оны 1-р улирлын тайланг 6 дугаар хуралдаанаар, жилийн эцсийн тайланг 15 дугаар хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, цахимаар сурталчилсан. Тус салбар зөвлөл 2015 онд 15 хуралдаан хийж, 60 асуудал шийдвэрлэснээс 100%-42, 90%-15, 70%-2, 50%-1, нийт шийдвэрийн хэрэгжилт 95,66 хувьтай, 2016 оны 1-р улиралд 4 хуралдаанаар 23 асуудал шийдвэрлэснээс 100% хэрэгжилттэй 22, 90 хувь 1, хэрэгжилтийн хувь 99,6%-тай байна. Эрүүл мэндийн газраас Эдийн засаг, удирдлага мэдээллийн хэлтсийн дарга, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргын албан тушаалд тухайн ажлын байрны шаардлагыг өөрчлөх, сонгон шалгаруулалтыг дахин хийх талаар санал, зөвлөмжийг ТАСЗ-ийн 2016.01.08-ны 05 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд энэ асуудлын хэрэгжилт хариу ирээгүй байгаа учир дахин зөвлөмж хүргүүлэв.

2016 оны эхний хагас жилд 10 хуралдаан хийж 44 асуудал шийдвэрлэснээс 100% хэрэгжилттэй 40, 90 хувь 4, хэрэгжилтийн хувь 99,1%-тай, жилийн эцсийн байдлаар 14 хуралдаан хийж, 65 асуудал шийдвэрлэснээс 100% хэрэгжилттэй 62, 90 хувьтай 3, хэрэгжилтийн хувь 99,54%-тай байна.

Салбар зөвлөлийн хуралдаанаас гаргасан 2015 оны болон 2016 оны 1-р улирал, эхний хагас жилийн шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн, зарим байгууллагуудад шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар албан тоот өгч, хариуцсан гишүүдэд үүрэгжүүлж хэрэгжилтийг хангуулж ажиллалаа. */Салбар зөвлөлийн 2016 оны хуралдаанаар хэлэлцсэн асуудлын төлөвлөгөө, шийдвэр, түүний хэрэгжилтийг хавсаргав./*

Хуралдааны тэмдэглэлийг хуралдаанаас хойш 3 өдрийн дотор албажуулах талаар Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажлын төлөвлөгөөнд тусган бүрэн хөтөлж албажуулсан.

Дөрөв. Орон нутаг салбарын хэмжээнд хууль, журам заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхт хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал, үр дүн

Төрийн албаны стандарт, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалган туслах ажлын байнгын удирдамжийн дагуу салбар зөвлөлийн гишүүд хариуцсан сум, байгууллага, хэлтэс, агентлагууддаа төрийн албаны хууль тогтоомж, журам зааврын хэрэгжилтийн явцыг эрчимжүүлэх ажлыг явуулж, хууль, тогтоомж, журам зааврын зөрчлийг арилгуулах, гарсан шийдвэрийг хангуулах арга хэмжээ тогтмол авч ирлээ.

Салбар зөвлөлүүдийн 2015 оны үйл ажиллагааны тайланд хийсэн үнэлгээний дүнг хэлэлцээд Төрийн албаны зөвлөлөөс салбар зөвлөлүүдэд ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ТАЗСЗ-ийн 2016 оны 5 дугаар хуралдаанаар хэлэлцэн баталж, хагас бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэж ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилээр 94,67 хувьтай, бүтэн жилээр 96,84 хувьтай байна. */Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав./*

Сум байгууллагын төрийн албаны стандартын 2015 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн дүгнэж, ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийн тайлан авч нэгтгэн дүгнэж байна. */Төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх талаар салбар зөвлөлөөс төрийн байгууллагуудад өгсөн зөвлөмжийг хавсаргав/*

Цагаандэлгэр, Дэлгэрцогт сумдын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн бодлого, төрийн албаны стандартын хэрэгжилтийн тайлан сонсголыг Салбар зөвлөлийн 2016 оны 12 дугаар хуралдаанаар хэлэлцэж, байгууллага бүрт үүрэг чиглэл, Төрийн бүх байгууллагуудад зөвлөмж хүргүүлээ. Байгууллага бүр зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган биелэлтийг жилийн эцсийн тайлангийн хамт ирүүлэн нэгтгэн дүгнэж байна.

/Цагаандэлгэр, Дэлгэрцогт сум, Эрүүл мэндийн газарт өгсөн үүрэг даалгавар, Төрийн байгууллагуудад өгсөн зөвлөмжийг хавсаргав./

Тав. Орон нутаг салбарын хэмжээнд хууль, журам заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн

Хууль, журам, заавар төрийн албаны стандартын хэрэгжилтэнд 2016 оны 1 сард хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг ХШҮТ-тай хамтран тусгай удирдамжийн дагуу зохион байгуулсан.

Хяналт шалгалтын явцад сумд байгууллагуудын стратеги төлөвлөгөөгөө шинэчилсэн, Төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөртэй түүнийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөө гарган ажилласнаар төрийн албаны үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан, сум байгууллагуудад албан хаагчдыг амьдрах орон сууцаар хангасан, аймгийн туршлагын санд багш нарын хичээл, болон багш нарын сурган хүмүүжүүлэх илтгэлийг оруулж бүртгүүлсэн, Төрийн албан хаагчийг төрийн албан хаагчдаас санал авч шалгаруулсан, албан хаагчдаа дотооддоо болон гадаад улсад туршлага судлуулсан, иргэдээс төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, ёс зүйн талаар санал асуулга авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн, байгууллага бүр төрийн албан хаагчдын судалгааг жил бүр шинэчилж хэвшсэн, Төрийн албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон ёс зүйн харилцааны ур чадварыг хөгжүүлэх замаар иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлийн ярилцлага хэлэлцүүлэг зохион байгуулсан, Төрийн захиргааны албан хаагчдын ажлыг улирал бүр тусгай шалгуур үзүүлэлтээр дүгнэж, үнэлгээний дүнг жилийн эцсийн ажлын үзүүлэлтэд оруулан дүгнэдэг зэрэг ажлын сайн туршлагауд байлаа.


Мөн үүний зэрэгцээ ажлын зөрчил дутагдал байгааг арилган сайжруулах чиглэлийг холбогдох байгууллагуудад зөвлөмжөөр өгч, сум байгууллагуудад гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж хэвшсэн.

Зургаа. Төрийн байгууллагын албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн. Төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн

Төрийн бүх шатны байгууллагад төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, төрийн албаны шинэчилсэн стандартуудыг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын мэргэшлийг тасралтгүй дээшлүүлэн чадваржуулж төрийн албаны залгамж чанарыг дархлаажуулах, төрийн үйлчилгээний нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллахад гол анхаарлаа хандуулан ажиллаж ирлээ.

“Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох аймгийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлыг бүх төрийн байгууллагуудад зохион байгуулж, байгууллага бүр сургалтын хөтөлбөр, жил бүрийн төлөвлөгөөтэй ажиллаж ирсэн. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдах сургалтын графикийг улирал тутам гарган хэрэгжүүлж 2012-2016 онд давхардсан тоогоор 540 удаагийн сургалтанд 19840 төрийн албан хаагчид хамрагдсан байна. Үүнийг он оноор харуулбал:

АЙМГИЙН ТӨВД СУРГАЛТАД ХАМРАГДСАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД /оноор/



Мөн төвийн нэгдсэн сургалтад 1131 төрийн албан хаагч хамрагдсан байна.

Байгууллагууд жил бүр албан хаагчдынхаа сургалтын хэрэгцээний судалгааг авч нэгтгэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

2016 онд аймгийн сургалтын төлөвлөгөө, графикийг

улирал тутам боловсруулан хэрэгжүүлж, салбарын шугмаар төвийн нэгдсэн 31 удаагийн сургалт, семинаруудад 143 албан хаагч суралцсан байна. Аймгийн төвд нийт 64 удаагийн сургалтанд 2977 төрийн албан хаагч, Удирдлагын Академийн цахим сургалтанд 25 байгууллагын 192 хүнийг хамруулах санал хүргүүлснээс 24 байгууллагын 162 хүн хамрагдан мэдлэг боловсролоо дээшлүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд Ерөнхий менежерүүдийн хувьд үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, ажлын арга барил, менежментээр бусдыгаа хошуучлан ажиллаж байгаа Баянжаргалан сумын сургуулийн захирал Эрхлэгч Батпүрэв овогтой Цэцэгжаргал, Гурвансайхан сумын сургуулийн захирал Жамъянсүрэн овогтой Цэцэгдэлгэр, Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Баатар овогтой Хорлоо, Дэрэн сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Чулуунбаатар овогтой Баярмаа нарыг 2015 оны “Шилдэг менежер”-ээр шалгаруулан Салбар зөвлөлийн Өргөмжлөл, мөнгөн урамшуулал олгож тэдний арга туршлагыг сурталчлах ажлыг зохион байгууллаа.

“Төрийн албаны хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт

сургалтыг Нийгмийн хүрээний цаг үеийн ажил, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэхтэй холбогдолтой зарим асуудал, Эрх зүйн сурталчилгаа, мэдээллийн ажлын үр дүн, Мал өвөлжилт, хаваржилтийн байдал, 2016 оны сонгууль зохион байгуулах тухай, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөнд нийгмийн чиглэлээр тусгагдсан асуудлуудыг эрчимжүүлэх талаар мэдээлэл өгч, ярилцлага зохион байгууллаа.



Захиргааны Ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан ХЗДХЯ-тай хамтран 1 удаа, УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын ээлжит сонгуулийн дараа МУИС-ийн Хууль зүйн сургуулийн

багш, хууль зүйн ухааны доктор, профессор П.Одгэрэл, Д.Ганзориг нарыг урьж шинэ тутам хэрэгжиж буй “Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлал, үндсэн асуудлууд”, “Үндсэн хууль, Орон нутгийн удирдлага” зэрэг сэдвүүдээр Засаг даргын харьяа газар, хэлтэс, албадын дарга, төрийн албан хаагчид болон аймгийн ИТХ-ын төлөөлөгч нарыг хамруулан эрх зүйн сургалтыг тус тус зохион байгуулсан. Дээрх сургалтуудад нийт 195 хүн хамрагдсан.

Байгууллагууд жил бүр албан хаагчдынхаа сургалтын хэрэгцээний судалгааг авч нэгтгэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг дарга, агентлагын дарга нартай бхйгуулсан үр дүнгийн гэрээнд төсвийн байгууллага бүр суралцагч байгууллага болох чиглэлд туршлага хуримтлуулан ажиллах зорилт дэвшүүлэн үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэн эрчимжүүлж ажиллалаа. Төрийн байгууллагуудад дараахь бүтээлч ажлуудыг хийсэн байна. Үүнд:

Гэрбүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас албан хаагч бүрт сургалт зохион байгуулах чадвар эзэмшүүлэх, мэдээллийг бусадтай хуваалцах чадвар эзэмшүүлэх зорилгоор төрийн албан хаагчийн заавал судлах хуулаар Даваа гаригт хуулийн сургалтыг зохион байгуулж өөрсдийн хамрагдсан сургалт болон семинар, шинээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжуудаар сургалтыг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж, “Төрийн албан хаагчийн имиж, хандлага”-ын талаар сургалтыг 19 албан хаагчдад зохион байгуулсан.

Хүнс, хөдөө аж ахуйн газар “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр” боловсруулан баталж, цахим хуудас болон мэдээллийн самбараараа сурталчилсан байна. Албан хаагчдаас сургалтын эрэлт хэрэгцээний судалгаа авч, хөдөлмөрийн гэрээ үр дүнгийн гэрээнд нь тусган хэрэгжүүлж, давхардсан тоогоор 15 албан хаагчийг мэргэжлийн дагуу 64 өдрийн 32 удаагийн сургалтанд 1 албан хаагчийг Солонгос улсад 7 хоногийн сургалтанд тус тус хамруулсан байна.

Мэргэжлийн хяналтын газар 19 онлайн болон танхимын сургалт семинарт улсын байцаагч нарыг бүрэн хамруулж, 1 албан хаагч Засгийн газрын тэтгэлгээр БНСУ-д магистрийн сургалтанд хамрагдаж байна.

Байгууллагын хэмжээнд хуулийн сургалт, англи хэлний хичээл, бүжгийн, гар бөмбөгийн, монгол дээл цамц оёх 5 төрлийн сургалтыг тогтмол хичээллүүлсэн байна. Байгууллагын шуурхай цуглаанд ажилтан бүр сонирхолтой сэдэв бэлтгэн хичээл зааж албан хаагчдын илтгэх ур чадварыг дээшлүүлэн ажилласан байна.

Байгууллагын соёл зохион байгуулалт ажлын байрны нөхцөл байдалд албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг авахад сэтгэл ханамж 89,1 хувьтай гарсан байна.

Стандартчилал хэмжил зүйн хэлтэс Төрийн болон төрийн бус 27 байгууллагын 48 ажилтнаар хууль эрх зүй, төрийн үйлчилгээ, эдийн засаг, банк, санхүү, шүүхийн тогтолцоо, даатгал, татварын талаар 27 удаагийн сургалт зохион байгуулж албан хаагчдынхаа мэдлэг боловсролыг дээшлүүлсэн байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар албан хаагчдынхаа сургалтын хэрэгцээг тодорхойлоход 70 хувь нь албан тушаалын чиг үүргийн дагуу сургалтанд хамрагдах хүсэлтэй байсан учир төлөвлөгөө гарган 18 хүнийг сургалтанд хамруулсан байна. долоо хоног бүрийн пүрэв гаргийн 16.00 цагт “Хуулийн цаг” сургалтыг тогтмол зохион байгуулсан байна.

Эрдэнэдалай сум “Монгол бахархалын өдөр”-ийг тохиолдуулан төрийн захиргааны 15, үйлчилгээний 23 албан хаагчид тангараг сэргээх арга хэмжээг зохион байгуулж, “Багшийн ёс зүй” сэдэвт илтгэлийн 63 хүнд, “Багшид өгөх

зөвлөлгөө” сэдэвт сургалтыг 23 хүнд, Авлигатай тэмцэх газар, сумын ЗДТГ-тай хамтран төрийн албан хаагчдын харилцаа, харьцаа, ашиг сонирхлын зөрчил, Авлигын эсрэг хуулиар 1 өдрийн сургалтыг 216 албан хаагчдад хийсэн байна. Үүний үр дүнд төрийн албан хаагчдын харилцааны талаарх иргэдээс өгсөн сайн үнэлгээний дундаж өмнөх оноос 1,3 дахин өссөн байна.

Луус сум ЗДТГ-ын албан хаагчид 20 хүнийг хамруулан Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд туршлага судлах аялал зохион байгуулж, "Авлигын мөн чанар, хор хөнөөл", "Худалдан авах ажиллагаа, Санхүүгийн ил тод байдал", "Орон нутгийн төсвийн удирдлага" "Архив албан хэрэг хөтлөлт", Төрийн албан хаагчийн ёс зүй" зэрэг сэдвүүдээр сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан байна. Мөн "Угийн бичиг хөтлөх", Монгол бичгийн сургалт", "Англи хэлний сургалт"-ыг төрийн албан хаагчдад долоо хоног бүр явуулж анхан шатны мэдлэг олгосон. Мөн албан хаагчдыг гадаад сургах бодлого баримтлан Цэцэрлэгийн эрхлэгч багш, 2 хүнийг Улаан-Удэ хотод сургалтанд хамруулж, тайлангаа багш ажилчдад тавьлаа.

Сумын ИТХ-аас санаачлан зохион байгуулсан "Төрийн алба –мэдлэг, ур чадвар хариуцлага" сарын аяны хүрээнд ХХХИ-институтээс "Хувь хүний хөгжил төлөвшил" сургалтад нийт албан хаагчдыг хамруулж, байгууллага бүр хууль сурталчилах ажлыг зохион байгуулан гарын авлага тараан танилцуулга хийж, байгууллагууд "Бидний туршлага" үзэсгэлэн гаргаж туршлагаа солилцсон байна. "Сумын хөгжил биднээс эхлэнэ" илтгэлийн уралдаан, "Бидний бүтээх ажил санал асуулга" явуулж дүгнэсэн байна.

Багш ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлж сургалтанд хамруулах, ажлын байрандаа хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэх, нийгэм соёл олон нийтийн үйл ажиллагаанд оролцуулан идэвхижүүлж манлайлах, бие биенээсээ харилцан суралцах, мэдээллээ бусадтайгаа хуваалцах, төрийн үйлчилгээг иргэдэд үнэн зөвөөр хугацаа алдалгүй хүргэж алдаа гаргасан тохиолдолдоо уучлалт хүсэх, засч залруулдаг байх, ажилд хандах хандлага мэдлэг чадвараа дээшлүүлэхэд өөрийгөө хөгжүүлдэг, зөв зан чанар үйлээ эрхэмлэж бусдад нөлөөлж чаддаг байх зэргээр багш ажилтан бүр байнгын тасралтгүй суралцагч байх зорилтуудыг тавьж нэлээдгүй ажлуудыг зохион байгуулан үр дүнд хүрч байна

Ажлын байранд ёс зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, бага, суурь боловсролын шинэчилсэн хөтөлбөр, хичээлээс гадуурх үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр зэрэг чиглэлээр Ви-И-Ти-нет ТББ, ЗДТГ, БСГ-ын сургалтын алба, Нийгмийн даатгал, хөдөлмөрийн хэлтэс, Мэдээлэл технологийн үндэсний төв зэрэг байгууллагуудтай хамтран нийт 15 сургалтыг зохион байгуулж орц гарцыг тооцож ажилласан. Цэцэрлэгийн удирдлага, багш нар, хүүхэд хамгааллын баг, ХХХИ-институт, МХГазар, БСГазар, аймаг сумын ЗДТГазар, аймгийн ХГБХХэлтсийн мэргэжилтэн, сумын ТББайгууллагууд гэх мэт ажил мэргэжлийн онцлогуудыг харгалзсан сургалтууд зохион байгуулж, түүнд багаар ажиллах, дадлага ажил хийх, санал бодлоо хуваалцах, шинэ мэдлэг олж авах бататгах зэргээр оролцлоо.

Өндөршил сум Төрийн албан хаагчдын мэдлэг боловсрол мэргэжлийн түвшинг дээшлүүлэх хүрээнд давхардсан тоогоор нийт 99 албан хаагч урт болон богино хугацааны сургалтанд хамрагдаж өөрийн ур чадвараа дээшлүүлсэн. Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлж буй 5 байгууллагын хүрээнд нийт 44 удаагийн урт болон богино хугацааны сургалтад давхардсан тоогоор 288 төрийн албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлээд байна. Сургалтын арга хэмжээний зардалд 7956400 төгрөгийг зарцуулсан. Төрийн байгууллагын зүгээс иргэдэд чиглэсэн 12 удаагийн сургалт сурталчилгаа мэдээллийг хийж, сургалтад давхардсан тоогоор 446 иргэн хамрагдав.

Албан хаагчдын манлайлал ба оролцооны өндөр түвшинг хангах зорилгоор төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд байгууллагын соёл,

харилцаа сэдвүүдээр сургалтыг Оюуны хөгжил төвтэй хамтран зохион байгуулсан. Сургалтанд нийт 64 албан хаагч хамрагдсан.

Дэрэн сумын бүх төрийн байгууллагууд хүний нөөцийн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас жил тутам албан хаагчдад танилцуулан санал бодлыг сонсож, түүний мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байна.

Энэ онд төрийн байгууллагуудад шаардлагатай 6 мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, 18 багш сургалтанд хамрагдаж, 3 багш мэргэжил дээшлүүлж, ЭМТ-ийн 1 ажилтан, СӨБ-ийн 1 багш Соёлын төвийн номын санч, дуу хөгжмийн багш мэргэжил олгох сургалтанд, Засаг даргын орлогч төрийн удирдлагын магистрын сургалтанд хамрагдсан байна.

“Оюуны хөгжлийн институт” ТББ-тай хамтран зөв хандлага, багаар ажиллах, харилцааны соёл сэдвээр нийт төрийн албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгуулж, төрийн албан хаагчдын сургалтанд сумын хэмжээнд 6250,0 мян төгрөгийг зарцуулсан байна.

Адаацаг сум 2 хүнийг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулж, Сайнцагаан сумын улсын тэргүүний 3,4 дүгээр цэцэрлэг, Улаанбаатар хотын 32, 138 дугаар цэцэрлэгийн, Сэлэнгэ аймгийн Жавхлан сумын ЗДТГ-ын туршлагыг судалсан байна. Мерси кор ОУБ-тай хамтран “Менежмент”, “Төрийн албан хаагчийн ёс зүй ба ашиг сонирхол” сэдэвт сургалтыг зохион байгуулж 21 албан хаагчийг хамруулсан байна.

Долоо. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зохион байгуулсан ажил үр дүн

Төрийн байгууллагуудад Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй ажиллах талаар 2016 оны үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг сургалт семинараар сумдын ЗДТГ-ын дарга нарт өгч, эрчимжүүлж ажилласан.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь заалтын дагуу нийт сум, хэлтэс, агентлагууд байгууллагынхаа төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөртэй, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөтэй тухайн жилдээ 3-6 зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж ажилласан нь зохих үр дүнгээ өгч байна.

Сумдын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжид байгууллагуудын албан хаагчдын сургалт ба ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг шалгуур үзүүлэлтээр оруулан шалган дүгнэж заавар зөвлөмж өгч ажилласан.

Сумдууд шинэ ажилтнуудыг түр орон сууцаар хангах, зарим сум, байгууллагууд 20-24 айлын орон сууцыг хувийн хэвшилтэй гэрээ байгуулан бариулж байна. Төсөвтөө багтаан тэтгэмж тусламж үзүүлэх, түлшний хөнгөлөлт олгох, туслах аж ахуйн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг илүүтэй авч хэрэгжүүлсэн байна.

Төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцох шуурхай байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын техник хангамжийг нэмэгдүүлж, цахим программ нэвтрүүлэн үр дүнд хүрч байна.

Төрийн байгууллагуудыг стандартын цахим хуудастай болгож, И-оффис системийг хөгжүүлж, сум байгууллага бүрийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлтийг цахим орчинд шилжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэн хэвшүүлж байна.

Бүх сумдад интернетийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, цахим орчин бүрдүүлсэн. Байгууллага хоорондоо мэдээлэл солилцох, байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрээр сурталчилах боломж бүрдсэн. Энэ онд И-оффис программын хэрэглэгчийн тоог 100 гаруй хүнээр нэмэгдүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд ажилдаа амжилт гаргаж хамт олноо манлайлан ажилласан 3 байгууллагыг аймгийн “Тэргүүний хамт олон”-оор шалгаруулж, аймаг орны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан 7 иргэнийг “Аймгийн хүндэт иргэн”-ээр, 3 иргэнийг “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж алдаршуулан, 9 ажилтныг аймгийн “Тэргүүний ажилтан”, 25 малчныг аймгийн “Сайн малчин” цол тэмдгээр, 246 хүнийг “Хүндэт тэмдэг”-ээр, 299 иргэнийг “Жуух бичиг”-ээр, 2 залууг “Оюунлаг залуу” цомоор тус тус шагнаж урамшуулсан.

Найм. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэх ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн

Төсвийн байгууллагуудад томилгооны зөрчилгүй ажиллуулах зорилгоор захиалгыг үндэслэн 2012-2016 онд төрийн жинхэнэ албаны болон үйлчилгээний байгууллагын удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 26 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 9101 ажлын байрыг нийтэд зарлаж, 128 хүн сонгон шалгаруулалтад бүртгүүлж, үүнээс 69 нь шалгалтандаа тэнцэж 48 нь томилогдсон байна. Үүнийг оноор харуулбал:



Төсвийн байгууллагуудын санал, захиалгыг үндэслэн 2016 онд төрийн захиргааны 1, үйлчилгээний 7 байгууллагын дарга /эрхлэгч/-ын албан тушаалд томилогдох ажилтнуудын сонгон шалгаруулалтыг 3 удаа зохион байгуулсан.

Энэхүү 3 удаагийн сонгон шалгаруулалтаар 6 ажлын байранд 9 иргэн бүртгүүлж орсноос 4 иргэн тэнцэж, 2 иргэнийг нэр дэвшүүлж томилсон.

9 иргэнийг нь Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гарган сум, байгууллагын төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшүүлж, томилуулсан.

Сонгон шалгаруулалтыг УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол, ТАЗ-ийн 2013 оны 14 болон 60 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу зохион байгуулсан. Сонгон шалгаруулалт бүрийг явагдах өдрөөс 21 хоногийн өмнө Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, аймгийн www.Dundgovi.gov.mn сайт, орон нутгийн Дундговь, телевиз, аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбар, аймаг, сумдын Засаг дарга нарын шуурхай цуглаанд 3-4 удаа мэдээлэн сурталчилж, дүн мэдээг Төрийн албаны зөвлөлийн

www.csc.gov.mn сайт, Засаг даргын шуурхай цуглаан, мэдээллийн самбараар тогтмол сурталчилж хэвшсэн.


Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын сорилын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтад тэнцэж нөөцөд бүртгэгдсэн иргэдийн жагсаалтыг гаргаж, ил тод сурталчилж байна.

Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг явуулах аймгийн журам боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлийн 2015 оны 8 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн, 18 дугаар тогтоолоор баталгаажуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Ес.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод байдлыг хангасан байдал, үр дүн

Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийг сонгон шалгаруулах мэргэшлийн шалгалтыг 2012 оноос хойш цахим хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 333 ажлын байр нийтэд зарлагдаж, 800 иргэн бүртгүүлж, эдгээрээс 324 иргэн шалгалтад тэнцэж, өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авсан 97 иргэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тухайн ажлын байрандаа нэр дэвшүүлэн томилогдсон байна. Үүнийг оноор харуулбал:



Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалгыг үндэслэн Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2016 онд 2 удаа зохиж журам, удирдамжийн дагуу ил тод, нээлттэй зохион

байгуулж явуулсан.

Энэхүү 2 удаагийн мэргэшлийн шалгалтаар 23 ажлын байр зарлагдсанаас 20 ажлын байранд 168 хүн бүртгүүлж, эдгээрээс 60 хүн шалгалтандаа тэнцэж, өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авсан 14 иргэн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор тухайн ажлын байрандаа нэр дэвших болзол хангасан байна.

/Төрийн албаны мэргэшлийн шалгалтын мэдээллийг www.dundgovi.mn сайтын Төрийн албаны салбар зөвлөл талбарын Ил тод байдал хэсгийн Төрийн жинхэнэ албаны нөөц хэсэгт болон бусад мэдээллийн талбараар сурталчилж байршуулсан болно/

Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг ТАЗ-ийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан журам, зааврын дагуу зохион байгуулсан. шалгалт бүрийг явагдах өдрөөс 21 хоногийн өмнө Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, аймгийн www.Dundgovi.gov.mn сайт, орон нутгийн Дундговь, телевиз, аймгийн болон сумдын Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбар, аймаг, сумдын Засаг дарга нарын шуурхай цуглаанд 3-4 удаа мэдээлэн сурталчилж, дүн мэдээг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn сайт, Засаг даргын шуурхай цуглаан, мэдээллийн самбараар тогтмол сурталчилж хэвшсэн.

Аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд 26 хүний багтаамж бүхий цахим шалгалт явуулах байр бэлтгэн, шалгалтын явцын бичлэг хийж, танхимын гадна талд телевизээр шалгалтын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй харуулах боломж нөхцөлийг бүрдүүлж, шалгалтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан.



Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд хамрагдсан бусдаасаа хамгийн өндөр оноо авч 1-ээр гарсан 14 иргэнийг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлснээр 5 иргэн томилогдож, 4 иргэн томилогдохоос татгалзаж, 2 иргэнийг байгууллага нь томилохоос татгалзсан, 3 иргэн хариу ирүүлээгүй байна.

Төрийн албаны 2016 оны 10 сард зохион байгуулсан мэргэшлийн шалгалтанд бүртгүүлсэн 130 иргэдийн 68 нь буюу 52,31% нь Дундговь аймгийн харъяат биш иргэн орж байна.

Дундговийн харъяат биш хүмүүс шалгалтанд орохдоо тус аймагт ажиллана гэж өргөдөл бичиж өгдөг боловч 2016 онд 14 хүн нэр дэвшүүлснээс 50 хувь нь тухайн албан тушаалдаа очиж ажиллахгүй салбар зөвлөлийн ажлыг хүндрүүлж байгаа харъяат биш хүмүүс шалгалт өгсөнтэй холбоотой байна.

Иймд цаашид энэ нөхцөл байдалд дүгнэлт хийж, өргөдөл бичиж шалгалт өгсөн хүмүүсийг бусад салбар зөвлөлд шилжүүлдэггүй тухайн орон нутагт шалгалтыг хүчинтэй байлгадаг байх талаар зохих хууль дүрэм журамд өөрчлөлт оруулж, хэрэгжүүлэхийг хүсэлт болгож байна.

Арав. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн

Төрийн жинхэнэ албаны нөөцийн санг анх орох иргэний нөөц, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц гэсэн 2 ангиллаар бүрдүүлсэн.

2016 оны жилийн эцсийн байдлаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн санд дэс түшмэлийн 60, туслах түшмэлийн 20 нийт 80 иргэн бүртгэлтэй байгаа. /Төрийн жинхэнэ албан нөөцийн мэдээллийг www.dundgovi.mn сайтын Төрийн албаны салбар зөвлөл талбарын Ил тод байдал хэсгийн Төрийн жинхэнэ албаны нөөц хэсэгт байршуулсан болно./

Нөөцийн сангийн баяжилтийг тогтмол хийж, нөөцийн бүртгэлд байгаа иргэдийг мэргэшлийн чиглэлээр нь ангилан, нэрсээр нь тодруулж гарган, 18 байгууллагад нөөцийн мэдээллээр үйлчилсэн байна. Нөөцийн сангийн мэдээллээ байгууллагууд цахим хуудаснаас авч байна.

Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоо, түүнийг нөхөх талаар авсан арга хэмжээний мэдээллийг орон нутгийн телевиз, Засаг даргын шуурхай цуглаан, семинар цугларалтын үеэр болон Салбар зөвлөлийн мэдээллийн самбараар нийтэд ил тод болгож, тогтмол мэдээлж хэвшсэн.

Салбар зөвлөлөөс сум, хэлтэс, агентлагуудын захиалгын дагуу нөөцийн жагсаалтад бүртгэлтэй байсан 16 иргэнийг захиалгат ажлын байранд нэр дэвшүүлж, 15 иргэн томилуулсан.

Удирдах ажилтны нөөцөд 2 хүнийг бүртгэж, хамгийн өндөр оноо авсан 1 хүнийг нэр дэвшүүлж томилуулсан.

Төрийн жинхэнэ албан хаагчдаас нэгжийн даргад нэр дэвшүүлсэн 9 хүний асуудлыг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн, дүгнэлт гаргаж томилуулсан.

Арван нэг. Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн санг бүрдүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөц бүрдүүлэх журам” –ын сум байгууллагад холбогдох заалтуудыг хяналтанд авч хэрэгжилтийг улирал тутам дүгнэн ажиллаж байна.

2016 онд төрийн албан хаагчийн нөөцийн жагсаалтанд 19 хүнийг шинээр бүртгэж, 8 хүнийг нөөцөөс нэр дэвшүүлж, 12 сарын байдлаар төрийн жинхэнэ албаны нөөцөд 25 хүн бүртгэлтэй байна.

Нөөцийн мэдээллийг Dundgov.gov.mn цахим хуудсны Төрийн албаны салбар зөвлөл талбарын “Ил тод байдал” хэсэгт байршуулан сурталчилж байна.

Арван хоёр. Төсвийн шууд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээг байгуулах, дүгнэх асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах дүгнэх журмын дагуу Сумдын Засаг дарга, төрийн захиргааны байгууллагууд, төсөвт байгууллагын дарга нартай байгуулах 2016 оны үр дүнгийн гэрээг байгуулсан.

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын болон төрийн захиргааны албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинд өгсөн үнэлгээг салбар зөвлөлийн хурлаар авч хэлэлцэн, зохих дүгнэлт өгч баталгаажуулан, цаашид анхаарах асуудлаар нийт сум хэлтэс, агентлагуудын удирдлагуудад зөвлөмж, чиглэл өгөх ажил хэвшил болсон.

Төрийн байгууллагууд зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, “Менежерийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-уудыг нийт сум, байгууллагуудад мөрдүүлэн ажиллаж, ерөнхий менежерүүдээс дээрх журам, заавруудыг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт шинжилгээ хийж, анхаарах асуудлуудаар тухай бүр нь заавар, зөвлөмж өгч арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

Ерөнхий менежер, удирдах ажилтнуудын манлайллыг аймгийн Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээг дүгнэх нэг харгалзах үзүүлэлт болгон авч үзэж байна.

Аймгийн Засаг даргаас хэлтэс агентлагийн дарга нар, сумдын Засаг дарга нартай 2015 онд үр дүнгийн гэрээний хэрэгжилтийн явцыг сумдын ЗДТГ-ын үйл ажиллагаанд явуулсан хагас, бүтэн жилийн ХШҮ-ний үеэр нийт сумдад шалган дүгнэж, цаашид ажил эрчимжүүлэх үүрэг даалгавар өгсөн.

Аймгийн Засаг даргаас бүх сумд, хэлтэс, агентлагийн дарга нартай байгуулсан 2015 оны үр дүнгийн гэрээг дүгнэж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийлээ. Үр дүнгийн гэрээний биелэлт 15 сумын Засаг даргаас 3 нь А, 11 нь В, 1 нь С, 22 агентлагийн даргаас 8 нь “А”, 8 нь “В”, 4 нь С үнэлгээтэй тус тус дүгнэгдсэн байна.

14 сумын Засаг даргын Тамгын газрын дарга үр дүнгийн гэрээгээ дүгнүүлснээс А үнэлгээтэй 9, В үнэлгээтэй 5, үнэлгээний дундаж хувь нь 90,89, 15 сумын ЗДТГ-ын 81 төрийн жинхэнэ албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэгдсэн бөгөөд А үнэлгээтэй 32, В үнэлгээтэй 40, С үнэлгээтэй 9 шалгагдаж, үнэлгээний дундаж хувь 88,93 байна.

Мөн төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээний мөрөөр журамд заасны дагуу шатлал ахиулах, шинээр зэрэг дэв олгох буюу өмнөх зэрэг дэвийг нь ахиулах, мөнгөн урамшуулал олгох зэрэг холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.

2015 оны үр дүнгийн гэрээний үнэлгээгээр А болон В үнэлгээ авч, зэрэг дэв олгох шаардлагыг хангасан 58 төрийн жинхэнэ албан хаагчдад аймгийн Засаг даргын 2016.01.27-ны А/28 дугаар, захирамжаар албан тушаалын зэрэг дэв шинээр олгуулах, өмнөх зэрэг дэвийг ахиулах арга хэмжээ авсан.

ЗДТГ-ын албан хаагчдын үр дүнгийн гэрээний үнэлгээний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж, 3 хүнд ажилласан жилийн нэмэгдэл, 6 хүнд мэргэжлийн зэргийн нэмэгдэл, 11 хүнд цалингийн шатлал ахиулж, холбогдох шийдвэрийг гаргасан.

Арван гурав. Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн

Төрийн албан хаагчдын дунд ёс зүйн, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах талаар сум байгууллагын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж байгууллагууд тусгай төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Аймагт нийт 23 төрийн захиргааны байгууллагад 3-7 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн хороо байгуулан ажиллуулж байна.

Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодын 2015 оны ажлын тайланг нэгтгэн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн, зөвлөмжийг хүргүүлж, байгууллагуудад хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргуулан, байгууллагуудын ёс зүйн хорооноос зохион байгуулсан ажил, ёс зүйн зөрчлийг хагас, бүтэн жилээр дүн мэдээг нэгтгэж дүгнэж эрчимжүүлж ажилласан.

Сум, байгууллагуудад Ёс зүйн хороог шинэчлэн байгуулах, төрийн албан хаагчидтай ёс зүйн гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах, төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийг мөрдөж ажиллах, төрийн албан хаагчдын ёс зүйн талаар иргэдээс сэтгэл ханамжийн үнэлгээ авч дүгнэлт хийж, үр дүнг төлөвлөгөөндөө тусгах, цаг баримтлах, цаг бүртгэх арга хэмжээ үр дүнтэй зохион байгуулах талаар ЗДТГ-ын даргын албан даалгавар гаргаж хэрэгжүүлэх, Ёс зүйг дээдлэгч хамт олон болох” сарын аян өрнүүлэх, байгууллага ёс зүйн зөрчил гаргасан ажилтанд ганцаарчилсан зөвлөгөө өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

Сум байгууллагын ирүүлсэн ёс зүйн хороодын 2015 оны тайланг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцээд гаргасан алдаа дутагдлыг арилгах тухай зөвлөмж гарган хүргүүлж, байгууллагын удирдлагуудын сургалтад зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөө өгч биелэлтийг дүгнэж ажилласан. Байгууллагуудад хийсэн ажлаас дурьдвал:

Эрдэнэдалай сум улирал бүр иргэдээс Төсөвт байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, мэдээллийн ил тод байдал болон төрийн албан хаагчдын харилцаа хандлагын талаар нийт 2110 иргэнийг хамруулсан санал асуулга авч, иргэдээс төрийн албан хаагчид харилцаа хандлагаа сайжруулах, цаг баримтлах, үйлчилгээг сайжруулах зэрэг санал шүүмжлэл гарсныг байгууллага бүр ажлын төлөвлөгөөндөө тусган дараахь ажлуудыг хийсэн байна..

Цаг баримтлах, цаг бүртгэх арга хэмжээ үр дүнтэй зохион байгуулах талаар ЗДТГ-ын даргын албан даалгавар гарч, байгууллага бүр “Ёс зүйг дээдлэгч хамт

олон болох”сарын аян өрнүүлэн, албан хаагчиддаа “Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл”, “Төрийн албан хаагчийн имидж, харилцааны соёл”, “Багшийн ёс зүйн дүрэм”, “Хүүхэд хамгаалал”, “Хүүхдийг хүчирхийллээс хэрхэн хамгаалах вэ”, “Ёс суртахуун”, “Анги удирдсан багш нарын арга зүйг дээшлүүлэх”, “Эмч үйлчлэгчидтэй хэрхэн харьцах вэ?”, “Эмнэлгийн мэргэжилтэн удирдлагатай яаж харьцах вэ”, “Ёс зүйн харилцаа хандлага” сэдвээр нийт 23 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 216 албан хаагчид хамрагдсан байна.

Өндөршил сум
“Байгууллагын соёл, ТАХ-ийн ёс зүй, харилцаа, хамтын ажиллагаа” сэдэвт сургалтыг “Оюуны хөгжлийн институт”- тай хамтран 64 төрийн албан хаагчийг хамруулан зохион байгуулсан байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах “Хишиг өдөр” арга хэмжээг 27 иргэнийг хамруулан зохион байгуулж, сургууль, цэцэрлэг, соёлын төвд ажилласан иргэд



тухайн байгууллагын нэг өдрийн ажлыг биечлэн хийж, ЗДТГ, ЭМТ-д ажилласан иргэд тухайн албан хаагчийн нэг өдрийн ажилтай танилцаж, ажилд нь туслан ажлын онцлог, ажил гүйцэтгэх арга барилтай танилцаж, сэтгэгдлээ хуваалцсан нь иргэд төрийн байгууллагын уялдаа холбоо сайжирсан нэг алхам боллоо.

Адаацаг сум Төрийн албан хаагчдын ёс зүйн дүрмийг албан хаагчдад сурталчлах зорилгоор “АХА” тэмцээн зохион байгуулж, Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж, төрийн албан хаагчдыг иргэдээр үнэлүүлэн, үнэлгээний мөрөөр тодорхой ажлуудыг зохион байгуулсан байна. Өдөрлөгт 413 хүн хамрагдсан байна.

Мэргэжлийн хяналтын газар Байгууллага дотроо “Манлайлал” сэдвээр эссэ бичлэгийн уралдаан зарлаж шалгаруулан, хэлэлцүүлэг зохион байгуулсан нь ажилтнуудын ёс зүй харилцаа, хандлагад сайн нөлөө үзүүлсэн байна.

“Зөв боловсон харилцаа” сэдвээр мэргэшсэн лекторын сургалт, хуулийн сургалтыг 7 хоног бүр 2-3 удаа тогтмол хийж, “Хамгийн шилдэг гарын авлага” шалгаруулсан байна. Мөн байгууллагаа архи тамхигүй орчин болгож, ёс зүйн доголдол гаргасан 4 албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулж, алдаа дутагдлыг засч ажилласан байна.

Онцгой байдлын газар байгууллагын бие бүрэлдэхүүний сахилгын зөвлөгөөнийг зохион байгуулж, “Эрсдэлт зан үйлээс татгалзъя, сахилга хариуцлага ёс зүйг дээдэлж, харилцааны зөрчилгүй хамт олон болж, ажлын чанар, хүртээмжийг дээшлүүлье” уриалга гарсан байна. Нийт бие бүрэлдэхүүнээс сэтгэл ханамжийн судалгаа, байгууллага сурталчлах өдөрлөгөөр 875 иргэнээс үйл ажиллагааны талаар асуумж авч үйл ажиллагаандаа дүгнэлт хийн, цаашид төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхээр болсон байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар Нээлтэй хаалганы өдөрлөгийг Сайнцагаан, Дэлгэрцогт сумдад зохион байгуулж, газар эзэмшил, өмчлөл, газрын төлбөрийн мэдээллийг 100 гаруй иргэнд өгч, кадастрын зургаар үнэ төлбөргүй үйлчилж, 300 гарын авлагыг тараасан байна.

Арван дөрөв. Өргөдөл гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хагас бүтэн жилээр ирүүлсэн байдал:

Иргэдээс болон төрийн албан хаагчдаас салбар зөвлөлд 21 өргөдөл ирснийг 13-ийг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, бусдыг нь шууд хариу өгөх замаар шийдвэрлэсэн.

Ирсэн өргөдлийг бүтцээр нь авч үзвэл нөөцөөс нэр дэвшүүлэх буюу ажилд орохыг хүссэн 8, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгүүлэх, үлдээх тухай 7 байгаа нь хамгийн их буюу нийт ирсэн өргөдлийн 40 гаруй хувийг эзэлж байна. Ажилд буцаан оруулах тухай 4 өргөдөл, бусад 2 ирсэн байна.

Төрийн жинхэнэ албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ыг баримталж Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өмнөх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болгоход анхаарч, салбар зөвлөлд ажлаас чөлөөлснийг эс зөвшөөрч ирүүлсэн 3 өргөдлийг журмын дагуу маргаан хянан шийдвэрлэх комисс томилон шийвэрлэж 1 өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа байна.

Ёс зүйн зөрчлийн мэдээг хагас жил тутам авч нэгтгэн дүгнэж хэвшсэн. 2016 оны эхний хагас жилийн ёс зүйн мэдээг нэгтгэж ТАЗ-д хүргүүлсэн. Төрийн захиргааны 4 байгууллагын ёс зүйн хороонд 6 төрийн захиргааны албан хаагчтай холбогдолтой гомдол ирснийг шийдвэрлэсэн байна. Үүнээс 1 төрийн албан хаагч сануулах, 2-т цалин бууруулах, 1 хүнийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулсан байна. Жилийн эцсийн тайлан мэдээг авч нэгтгэхэд нэмж зөрчил илрээгүй байна.

Арван тав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн:

Салбар зөвлөлөөс хийсэн ажлын тайланг 7 хоног тутам Засаг даргын шуурхай цуглаан болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчилан ажиллаж байна.

Дундговь аймгийн Dundgovi.gov.mn цахим хуудсанд Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах “Төрийн албаны салбар зөвлөл” талбар нээн үйл ажиллагааг нь тогтмолжуулаад байна. Уг талбарт танилцуулга, шалгалтын зар, ил тод байдал, тогтоол шийдвэр, эрх зүйн акт, холбоо барих зэрэг булан нээн үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж хэвшсэн.

Дундговь аймгийн Dundgovi.gov.mn цахим хуудсанд Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах “Төрийн албаны салбар зөвлөл” талбар нээн үйл ажиллагааг нь тогтмолжуулаад байна. Уг талбарт танилцуулга, шалгалтын зар, ил тод байдал, тогтоол шийдвэр, эрх зүйн акт, холбоо барих зэрэг булан нээн үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж хэвшсэн.

2016 онд удирдах ажилтны сонгон шалгаруулалт, мэргэшлийн шалгалт, төрийн албан хаагчийн нөөцийн зар, хуралдааны тойм, шийдвэрийн хэрэгжилт, шалгалтын дүн, салбар зөвлөлийн тогтоол, төлөвлөгөө, тайлан, төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн мэдээлэл зэрэг нийт 33 мэдээллийг шинээр тавьж нийтэд үйл ажиллагаагаа сурталчилсан. Мөн түүнчлэн аймгийн Дундговь телевизид 8 удаа, Засаг даргын шуурхай цугтаанд 7 хоног бүр буюу нийт 70 гаруй удаа үйл ажиллагааныхаа талаар мэдээлсэн байна.

Бүх сумдын төв, малчдад мэдээлэл хүргэдэг Аюулаас урьдчилан сэргийлэх цогцолборын FM радиогоор сар бүрийн 1-ны өдөр сарын хийсэн ажлын мэдээлэлээ дамжуулсан.

Төрийн албаны мэргэшлийн шалгалт, төрийн жинхэнэ албаны болон төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар мэдээллийг ТАЗ-ийн болон аймгийн вэб сайт, Засаг даргын шуурхай мэдээлэл, орон нутгийн Дундговь, Маргад телевиз, аймаг, сумын ЗДТГ-ын мэдээллийн самбараар мэдээлж сурталчилж хэвшсэн.


Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг цахим хэлбэрээр явуулж, шалгалтын үйл ажиллагааг аймгийн ЗДТГ-ын бага заланд 20-26 хүний багтаамж бүхий цахим шалгалт явуулах байр бэлтгэн, шалгалтын явцын бичлэг хийж, танхимын гадна талд телевизээр шалгалтын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй харуулах боломж нөхцөлийг бүрдүүлж, шалгалтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан.



Шалгалтын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах техник тоног төхөөрөмжөөр хангах төсөл бичиж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн 7 компьютер техник хэрэгслээр хангаад байна.

Мэдээллийн ил тод шуурхай байдлыг хангах зорилтын хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газрын нэг цонхны үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэн тус төвд олон нийттэй харилцах ажилтныг ажиллуулж байна.

“Нээлттэй хаалганы өдөрлөг”, аймгийн “Засаг даргын 100 хоног”, “Авлигын эсрэг Олон улсын өдөр” зэрэг арга хэмжээнүүдээр төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг 1034 иргэнд, мөн “Иргэний улс төрийн эрхийн тухай” хуулийн төслийн танилцуулга, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, албан тушаалтны хариуцлагыг нэмэгдүүлж, хяналт оролцоог хангах нь” уулзалт хэлэлцүүлэгийг 345 иргэнийг оролцуулан нийт 1380 гаруй төрийн албан хаагчид болон иргэд, олон нийтийг хамруулан зохион байгууллаа.



Бүх шатны төрийн байгууллагын бодлого, үйл ажиллагаа, нийгмийн хүндрэл бэрхшээл, асуудлын талаарх иргэдийн санал гомдлыг хүлээн авч холбогдох төрийн байгууллагад хүргэн шийдвэрлүүлэх, хариуг иргэдэд түргэн шуурхай хүргэх цахим үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Санал өргөдөл гомдлын цахим сайтад 439 санал хүсэлт, өргөдөл гомдол бүртгэгдсэн бөгөөд

шийдвэрлэлт 88.8%-тай байна. Иргэдээс ирсэн санал хүсэлтийг тухай бүр цахим программд оруулж, холбогдох газруудад хуваарилан шийдвэрлүүлээ. Мөн Засгийн газрын цахим сайт 11-11 төвд ирсэн 11 асуудлыг судлан хариуг өгч шийдвэрлэлтийн хувь-100% байна.

Мөн цахим өргөдөл гомдлын сайтад иргэдийн хүсэлтийг 24 цагийн туршид хүлээн авч байх үүднээс дуудлага хүлээн авах утсыг бий болгож 24 цагийн турш санал хүсэлтийг сонсож байна.

Ирсэн СӨГ-ийн шийдвэрлэлтийг Вэб сайт, FM, TV, орон нутгийн болон, Зууны мэдээ сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байна.

Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах шийдвэрлэх талаар хийсэн ажлаа иргэдэд тайлагнах, иргэдийн санал бодлыг сонсох “Нээлттэй уулзалтын өдөр”-ийг 21 хоногт тутам хийхээр төлөвлөж, нийт 4 удаа зохион байгуулж 600 гаруй иргэд, ТАХ-дыг хамруулан тэдний тавьсан асуулт, санал, гомдлуудад тодорхой хариуг өглөө.

Монгол улсын Их хурлын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Монгол улсын Засгийн газрын 100 хоногийн хүрээнд аймгийн ЗДТГ-аас төрийн байгууллагуудын “Нээлттэй мэдээллийн өдөрлөг”-ийг зохион байгууллаа.

Төрийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлахын зэрэгцээ төрийн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэлээ.



Аймгийн Засаг даргын 100 хоног арга хэмжээг зохион байгуулж, өнгөрсөн 100 хоногийн хугацаанд ямар шийдвэр гаргаж ажил өрнүүлснээ салбар бүрээр нь тайлагнаж, цаашид хийхээр төлөвлөсөн болон аймаг орон нутагт тулгамдаж буй асуудлыг иргэдэд танилцуулсан.

Аймгийн Засаг дарга болон уулзалтанд оролцсон аймгийн удирдлагууд иргэдээс санал, хүсэлт, асуулт хүлээн авч хариулт өглөө. Уулзалтын үеэр

төрийн байгууллагууд иргэдэд үйл ажиллагаагаа танилцуулж мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлсэн байна. 400 орчим иргэд уулзалтанд хүрэлцэн ирж мэдээлэл авлаа.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Конрад-Аденауэрын сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим Дундговь аймгийн ЗДТГ хамтран “Нэг говь нэг зорилго” говийн бүсийн чуулганыг Мандалговь хотод зохион байгуулж 300 гаруй төлөөлөгчид оролцлоо.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс 21 аймгийн 2015 оны өрсөлдөх чадварын тайланг танилцууллаа. Судалгаагаар говийн бүсийн хөгжлийн тулгуур нь мал ахуй, тэр дундаа тэмээний аж ахуй, уул уурхай, боловсруулах үйлдвэр, аялал жуулчлал, сэргээгдэх эрчим хүч, барилгын материалын үйлдвэрлэл гэж тодорхойлсон байна.



Дундговь аймгийн тухайд эдийн засгийн идэвхитэй хүн ам, орлогын тэгш бус байдал, чанаргүй зээлийн үлдэгдэл бага, зээл авах боломж, дундаж наслалт өндөртэй, багш сурагчийн харилцаа сайн гэсэн эерэг үзүүлэлтийг гаргасан бол эдийн засгийн хөгжлийн түвшин, эдийн засгийн төрөлжилт, аймгийн төсвийн удирдлага, ил тод байдал, мэргэшсэн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, цэвэр усны хүртээмж тааруу байгааг судалгаагаар гаргажээ.

Цаашид Дундговь аймгийн хувьд аймгийн удирдлагын тогтвортой байдлыг хангах, бизнес эрхлэгчдийг татвар зээлийн бодлогоор дэмжих, банкны зээлийн хугацааг уртасгаж хүүг бууруулах, аймгийн урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулах, батлуулах, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, аялал жуулчлалын хөгжүүлэхээр боллоо.

Арван зургаа. Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээ ирүүлсэн байдал

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны программ хангамж, техник хангамж, сүлжээний ашиглалт, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Аймгийн ЗДТГазар нь сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудтайгаа харилцан мэдээллийн эргэх холбоог шуурхай болгох үүднээс хүний нөөц, ажил хэрэг, цаг бүртгэл, албан бичиг, хэлэлцүүлэгийн зэрэг программыг багтаасан байгууллагын удирдлагын "E-office" цогц системийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, 2016 онд хамрах хүрээг 100 гаруй албан хаагчаар өргөжүүлээд байна.

МСҮТ-ийн дэргэдэх Говийн бүсийн арга зүйн төвийн мэдээлэл, технологийн лаборатор, Боловсрол соёлын газар болон аймгийн Засаг даргын Тамгын газрыг түшиглэн төрийн албаны мэргэшлийн шалгалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн, төрийн албаны мэргэшлийн шалгалт болон удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулж хэвшээд байна. Ингэснээр шалгуулагчдын сэтгэл ханамж дээшилсэн.

Аймгийн хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн программыг шаардлагатай ажилтнуудын компьютерт суулгаж өгсөнөөр холбогдох ажилтнууд уг тайлан мэдээ, судалгааг өөрсдийн ажил төрөлдөө өргөн ашиглах болж бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн үр өгөөж дээшилж ирсэн.

2015 оны ТАХ-ын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг шинэчлэн гаргаж мэдээллийн баазыг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 38 байгууллага, сумдын 98, нийт 136 байгууллагыг хамруулан бүрдүүлж, тайланг ТАЗ-д хүргүүлсэн. 2015 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд ТАХБХТайланг нэгтгэн мэдээллийн баазийг бүрдүүллээ.

Аймгийн хэмжээнд төсвийн 136 байгууллагад 3241 төрийн албан хаагч ажиллаж байна. Үүнээс 379 буюу 11,87% нь Төрийн захиргааны албан хаагч, 111 буюу 3,47% нь улс төрийн албан хаагч, 104 буюу 3,25% нь төрийн тусгай, 2647 буюу 81,25 % нь төрийн үйлчилгээний албан хаагч ажиллаж байна.



Төрийн албан хаагчдыг насны бүтцийн хувьд авч үзвэл 35 хүртэлх насны залуучууд 1423 буюу 44,59 %, 36-50 хүртэл насны идэр насныхан 1325 буюу 41,52%, 51-ээс дээш настай 443 буюу 13,88 хувийг эзэлж байна.

Төрийн албан хаагчдын тоо бүртгэлийн судалгааг 2016 оны эхний хагас жилийн байдлаар сум хэлтэс агентлагаас авч нэгтгэн ТА3-д хүргүүлээ. Судалгаагаар 2016 оны 06 сарын 15-ны байдлаар аймгийн хэмжээнд 137 төрийн байгууллагад 3264 орон тоонд 3256 хүн ажиллаж байна

2016 оны ТАХ-ын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 36 байгууллага, 15 сумыг хамруулан гаргах хуваарь, заавар зөвлөмжийг хүргүүлэн хуваарийн дагуу тайланг нэгтгэж байна.

Байгуулагуудад төрийн албан хаагчийн мэдээллийн баазийг бүрдүүлэх зорилгоор Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргах программын талаар Засаг даргын эрхлэх хүрээний агентлагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, нийт 29 албан хаагч хамрагдсан.

Бүх төрийн байгууллагууд 2016 оны Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн баазтай болж, түүнийгээ үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Арван долоо. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил, үр дүн

Салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах ажлын хүрээнд ажлын төлөвлөгөөнд гишүүдийн ажил үүргийн хуваарийг мөрдөж дүгнэж ажиллах, тэдний ажлыг үнэлэх шалгуур гаргаж, урамшуулал олгох, салбар зөвлөлийн гишүүдэд хурлын мэдээллийг цахим шуудангаар болон бичгээр хүргэж, хуралд оролцохдоо холбогдох хууль, журмууд судлах боломжийг бүрдүүлэх, төрөл бүрийн сургалтуудад хамруулах зэрэг ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Салбар зөвлөлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх үүднээс “Салбар зөвлөлийн хуралдааны дэг”, ТАСЗ-ийн 2014 оны 14, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь”-ыг 2016 оны 08 дугаар тогтоолоор, “Салбар зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох журам”-ыг 2016 оны 12 дугаар тогтоолоор тус тус баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Сум, байгууллагуудыг салбар зөвлөлийн гишүүдэд хариуцуулан ажиллаж, үр дүнг бүтэн жилээр тооцож дүгнэж хэвшсэн. Салбар зөвлөлийн гишүүд хариуцсан сум байгууллагатайгаа тогтмол харилцаатай байж, тухай хуралдааны шийдвэр болоод бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тухайн сум байгууллагын албан хаагчидтай холбогдолтой санал өргөдөл гомдлыг шийдвэрлэх, Төрийн

албаны зөвлөлд хэлэлцүүлэх сонсголыг бэлтгүүлэх зэрэг чиглэлд хамтран ажиллалаа. Үүний үр дүнд сум байгууллагуудад төрийн албаны стандартын хэрэгжилт сайжирсан.

Салбар зөвлөлийн гишүүдийн ажлыг үнэлж дүгнэх журмыг боловсруулан, салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж, 2014 онд 1940,0, 2015 онд 1 720, 2016 онд 2000,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь тэдний идэвхи санаачилгыг өрнүүлсэн ажил болсон. 2016 онд журмыг шинэчилэн баталж урамшууллын хэмжээг нэмэгдүүлээд байна.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд www.Dundgovi.gov.mn аймгийн вэб сайтын “Төрийн албаны салбар зөвлөл” талбар нээн ажиллуулж, Төрийн албаны салбар зөвлөлийн танилцуулга, тогтоол шийдвэр, эрх зүйн акт, шалгалтын зар, ил тод байдал хэсгүүдээр салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, ажил үүргийн хуваарь, ажлын төлөвлөгөө тайлан, салбар зөвлөлийн хуралдааны шийдвэр, удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар, дүн, мэргэшлийн шалгалтын зар, дүн, төрийн жинхэнэ албаны нөөцийн мэдээлэл зэрэг үйл ажиллагаагаа тогтмол сурталчилж байна. Үүний үр дүнд байгууллагууд болон төрийн албан хаагчид мэдээллийг хурдан шуурхай авч үйл ажиллагааны шуурхай байдал хангагдаж байна.

Салбар зөвлөл 2005 оноос эхлэн байгууллагуудын удирдах албан хаагчдын ажлын эрчимжүүлэх, сэдэлжүүлэх үүпнээс аймгийн “Шилдэг менежер шалгаруулах журам”-ыг батлан хэрэгжүүлж, нийт 33 шилдэг менежер шалгаруулаад байна. Энэ нь төрийн байгууллагуудад стандартыг хэрэгжүүлэхэд үр дүнгээ өгсөн арга хэмжээ гэдэг нь харагдаж байдаг.

Салбар зөвлөлөөс байгууллагуудад төрийн албаны стандартын хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс Төрийн албаны стандартын хэрэгжилтийн талаар тайлан ирүүлэх загварыг 2015 оны 10 дугаар хуралдаанаар хэлэлцэн баталж, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумын ЗДТГ, ХХААГ, Эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн бодлого, төрийн албаны стандартын хэрэгжилтийн тайлан сонсголыг ТАСЗ-ийн хурлаар хэлэлцэж, зөвлөмж чиглэл өглөө. Загварын дагуу 2015 оны ажлын тайлан мэдээллийг авч нэгтгэж байна. Үүний үр дүнд байгууллагууд төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх ажлаа цэгцтэй төлөвлөж, тайлагнаж байна.

Арван найм. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтийн /иргэдийн/ үнэлгээ

Тайлангийн хугацаанд Сум, байгууллагын удирдлага, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, албан хаагчид нийт 20 гаруй хүнийг хүлээн авч уулзан, тэдний санал бодлыг сонсох, тавьсан асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүллээ.

Төрийн албанд анх орох иргэдийн нөөцийн мэдээллээр 18 байгууллагад, төрийн албаны мэргэжлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалттай холбогдолтой хууль тогтоомжийн талаар 180 гаруй хүнд сургалт зөвлөгөө өгсөн.

Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд иргэдийн үнэлгээ хийлгэх ажлыг цахим хэлбэрээр явуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

Арван ес. Салбар зөвлөлийн хагас, бүтэн жилийн тайлан ирүүлсэн байдал:

2016 оны хагас, бүтэн жилийн ажлын тайлан, мэдээг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 126 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн ажил дүгнэх үзүүлэлт”-ийн дагуу гаргаж хүргүүлж байна. Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, 2016 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2016 оны төрийн албаны

зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдааны шийдвэрийн биелэлтийг тус тус гарган хүргүүлж байна.

Хорь. Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг, даалгаврын биелэлт:

2016 онд салбар зөвлөлд Төрийн албаны зөвлөлөөс 16, бусад байгууллага, иргэдээс 211 нийт 227 албан бичиг тоот, 21 өргөдөл гомдол, санал хүсэлт ирж, салбар зөвлөлөөс Төрийн албаны зөвлөлд 23, бусад байгууллага, иргэдэд 100 нийт 123 албан тоот бичиг гадагш явуулсны дотор Төрийн албаны зөвлөлөөс шаардсан болон цаг үеийн графикт 4 тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн болно.

Хорин нэг. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг цаашид сайжруулахтай холбогдсон ажил хэрэгч санал

Салбар зөвлөлийн үйл ажиллагаа болон төрийн албаны зарим үйл ажиллагааг цаашид сайжруулахтай холбоотойгоор салбар зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг нэгтгэн хүргүүлж байна. Үүнд:

1. Сумын иргэдэд ижил түвшний төрийн үйлчилгээ үзүүлдэг Сумдын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд ТЗ-3, иргэний бүртгэлийн мэргэжилтэн, татварын байцаагч ТЗ-6, хөдөлмөр, халамжийн болон нийгмийн даатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн ТЗ-5 зэрэг ялгаатай зэрэглэлээр цалинжиж байна. Энэ ялгааг арилгаж сумын түвшинд ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг нэг түвшний цалингаар цалинжуулдаг болгох саналыг төрийн албан хаагчдаас байнга тавьж байгааг уламжилж байна.

2. Сумын Засаг даргын Тамгын газрын Газрын даамал, байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд улсын байцаагчийн эрх олгож, энэ ажлыг хавсран хийдэг. Энэ нь улсын байцаагч өөрийнхөө ажилд хяналт тавих зөрчил үүсч байгаа тул сумдад байгаль орчны улсын байцаагчийн тусгай орон тоог бий болгох шаардлагатай байна.

3. Боловсрол, Эрүүл мэндийн салбарт 25–аас дээш жил ажилласан бичиг хэргийн ажилтнуудын тэтгэмжийг тухайн салбарын хуулиар зохицуулсан байна.

Аймаг, сумын ЗДТГ-ын бичиг хэргийн ажилтнууд тэтгэвэрт гарахдаа Хөдөлмөрийн хуульд заасны дагуу 1 жил хүрэхгүй цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж баталж өгдөг. Төрийн захиргаанд олон жил бичиг хэргийн ажилтнаар ажиллаад тэтгэвэрт гарч байгаа албан хаагчид тэтгэмжийг 36 сараар авах гомдол гаргаад байдаг. Иймд ижил түвшний албан хаагчдад ижил түвшний тэтгэвэр олгох хуулийн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

4. Нэг ижил ажлын байранд тавигдах шаардлага байгууллага бүрт харилцан адилгүй байгаа нь тухайн ажлын байрны зохих шаардлагыг хангахгүй хүн томилогдох тохиолдол багагүй гарч байна. Иймээс тухайн ажлын байрны хамгийн доод жишиг шаардлагыг харъяалах салбарын яам болон зохих шатны дээд байгууллага нь гаргаж, тухайн жишигт нийцүүлэн байгууллага нь ажлын байрны шаардлагаа гаргадаг болгох асуудлыг хуулийн зохицуулалтад оруулж өгөх шаардлагатай байна.

5. Төрийн албаны мэргэшлийн шалгалт болон төрийн захиргааны удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд өөр аймаг хотын харъяалалтай хүмүүс ирж ажиллана гэж өргөдөл бичээд шалгалтад орчихоод нэгээр гарсан хэр нь очиж ажиллахгүй, ажлын байрны захиалгыг нөхөх ажлыг цалгардуулж байна. Иймд очиж ажиллаагүй хүмүүст хариуцлага тооцдог эрх зүйг бий болгох хэрэгтэй байна.